



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Нээлттэй хэлэлцүүлэг зохион
байгуулах тухай

Монгол улсын "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай"
хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-ийг заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Иргэдийн оролцоо-Өрхийн хөгжлийг дэмжих жилийн ажлын зорилтод бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцуулах, дэмжлэг үзүүлэх гэсэн заалтын дагуу гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийг тулгамдсан асуудал болон тэднийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, бэлэг дурсгалын чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулах, аялал жуулчлалын салбараас ашиг олох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагын төлөөлөл, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчид, иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаад даалгасугай.

Хоёр. Нээлттэй хэлэлцүүлэг явуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Нээлттэй хэлэлцүүлгийн төсөв болох 190,000 төгрөгийг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Хэлэлцүүлгийг цаг хугацаанд нь зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

4550
Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 20.09-ны 09 сарын 20 өдрийн
77 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго:

Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтан энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулах юм. "Монголд үйлдвэрлэв" гэсэн шошигтой бүтээгдэхүүний тодорхой хувийг гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хийж байна. Тэдний үйлдвэрлэсэн эсгий, арьсан, модон урлалын бүтээгдэхүүн өнөөдөр гадаад, дотоодын аялал жуулчлалын салбарын салшгүй нэг хэсэг болсон ч тэдэнд тулгамдсан асуудал багагүй байна.

Тиймээс тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх гарцыг хайх, энэхүү асуудлыг олон нийт, төр засгийнханд хүргэхэд хэлэлцүүлгийн зорилго оршино.

Түүнчлэн гар урлалын үйлдвэрлэл эрхэлдэг байгууллага болон иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, бэлэг, дурсгалын чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулах, аялал жуулчлалын салбараас иргэд ашиг олох боломжийг нээхэд чиглэгдэнэ.

Явуулах хугацаа:

2012.09.25-ны өдрийн 09.00-14.30 цагт

Хаана болох:

-Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд

Зохион байгуулагчид:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

-Нийслэлийн Аялал жуулчлалын газар

-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим

Оролцох байгууллага:

- Соёл , спорт, аялал жуулчлалын яам
- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Аялал жуулчлалын үндэсний төв
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Гаалийн ерөнхий газар
- Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэлийн хэлтэс
- Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн газар
- Жижиг, дунд үйлдвэрийн сан
- Олон улсын төсөл, хөтөлбөрүүд
- “Хаан банк”
- “Хас” банк

Хэлэлцэх сэдэв:

“Үнэгүйдсэн Монгол брэнд буюу гар урчуудын ганцаардал” сэдвийн доор тэдний тулгамдаад буй асуудлыг дугуй ширээний ярилцлага хэлбэрээр явуулна.

ХӨТӨЛБӨР

д/д	Хэлэлцэх асуудал	Хэлэлцүүлгийн сэдвийн дагуу илтгэл тавих хүн /илтгэл 10-15 минут/	Эхлэх болон дуусах цаг	Чөлөөт ярилцлага
1	Бүртгэл	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар -Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	09.00-09.30	11.30-14.00
2	Нээлт	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	09.30-09.45	
3	Гар урчуудын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал	Гар урчуудын төлөөлөл	09.45-10.00	
4	Төр засгаас явуулж байгаа бодлого	Соёл, спорт, аялал жуулчлалын яам	10.00-10.15	
5	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн талаар	Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн газар	10.15-10.30	
6	Гар урчуудын бизнесийг төрийн бус байгууллагаас дэмжих нь	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	10.30-10.45	
7	Улсын мэргэжлийн хяналтын газар	Стандартын талаарх мэдээлэл	10.45-11.00	
8	Цайны цаг		11.00-11.30	

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Ш. Ундармаа* Ш.УНДАРМАА

1858



Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 20/20-оны 29 сарын 20 өдрийн
4/ тоот тушаалын хоёрдугаар хавсралт

НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ / төгрөг/
1	Кофе, цай, ёотон	60	1500	90000
2	Бичиг хэргийн зардал	60	1366,6	82000
3	Анонс	1	18000	18000
	Дүн			190000

ХЯНАСАН:

АХЛАХ НЯ-БО

П.АРИУНАА